



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 18/122

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А64 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцад батлагдсан Аймгийн Засаг даргад хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн төсөл, арга хэмжээнээс сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/, барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/ нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

03 Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 08 өдрийн 2/122
дугаар захирамжийн хавсралт

| Д/д | Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр | Төсөвт өртөг | 2020 онд санхүүжих |
|-----|--|--------------|--------------------|
| 1 | Цэцэрлэгийн барилгын засвар /Хэнтий, Хэрлэн сум, 4 дүгээр цэцэрлэг/ | 20.0 | 20.0 |
| 2 | Цэцэрлэгийн дээврийн засвар /Хэнтий, Баян-Адарга сум/ | 15.0 | 15.0 |
| 3 | Спорт заалны барилгын засвар /Хэнтий, Хэрлэн сум, Хан Хэнтий цогцолбор сургууль/ | 15.0 | 15.0 |
| | Нийт дүн | 50.0 | 50.0 |